

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ГҮБ Б.ЭНХ-АМГАЛАНГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин		Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
			Суурь түвшин	Хүрэх түвшин			
	1	2	3	4	5	6	7

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

1	Мэдээллийн нэгдсэн санд дүн шинжилгээ хийж, өгөгдлийг боловсруулсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Хиймэл оюу ухаанд суурилсан БТКУС кодыг санал болгох системийг шинээр нэвтрүүлсэн байна.	Гадаад худалдаанд оролцогчид гаалийн мэдүүлгийг нөхөн бичихэд гарч буй хүндрэлийн нэг нь тухайн бараанд таарах зөв БТКУС-г олох асуудал байдаг учраас "Хиймэл оюу ухаанд суурилсан БТКУС код санал болгох систем"-г хөгжүүлж эхэлсэн. Импорт, экспортын барааны нэр, марк модел, онцлог шинж гэсэн талбаруудыг авч өгөгдлийн бэлтгэн, цэвэрлэж ДГБ-н БАКУДА төслөөс санал болгосон Doc2Vec моделийг ашиглан машин сургалтаар моделийг сургасан. Doc2Vec бол баримт (document) эсвэл текстийн цогц мэдээллийг векторын хэлбэрт хувиргаж, машин сургалтанд ашиглахад тохиромжтой хэлбэрт оруулах зориулалттай байгалийн хэл боловсруулалтын (NLP) аргачлал юм. Машин сургалтаар мэдүүлгийн өгөгдлийн сангаас сүүлийн 3н жилийн датагаар машин сургалтын хийж ассугасу буюу моделийн магадлал 80-с дээш хувьтай гарч системийн эхний хувилбар бэлэн болсон. Үүнийг Барааны ангилал, үнэлгээний хэлтэсээс туршилт хийж, ДГБ-г албан хүсэлтээр мэдэгдэж, 2025 онд нэвтрүүлэхээр төлөвлөж байна.	01.01-11.30	100
2	Программ хангамжуудыг шинээр боловсруулах, хөгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гаалийн автоматжуулсан мэдээллийн шинэчлэх, хөгжүүлэлтийг дотоод зурвасын дагуу хийж гүйцэтгэнэ.	Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийн шинэчлэх, сайжруулах хөгжүүлэлт <ul style="list-style-type: none"> БАУХ-ээс 2024.04.02-ны өдрийн 02-2.1/68 дугаартай дотоод зурвасаар ирүүлсний дагуу КАИС системийн Үнийн мэдээллийн сангийн мэдүүлгийн бичлэг цэснээс эжсел рүү хөрвүүлэхэд Хэлцлийн үнийн бааз руу мэдээлэл оруулсан гаалийн улсын байцаагчийн хувийн дугаарыг гаргах боломжтой болсон. БНХАУ-д экспортлох үйлдвэрийн зориулалтаар ашиглах мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнд олгох мал эмнэлгийн гэрчилгээг CAPS.GAALI.MN 	01.01-11.30	100

8911

				<p>СИСТЕМД ШИНЭЭР НЭМЭЛТ ХӨГЖҮҮЛЭЛТ ХИЙГДЭЖ ГЭРЧИЛГЭЭГ ОРУУЛАХ АЖИЛ ХИЙГДСЭН.</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас олгодог химийн хорт бодисын импортын зөвшөөрлийг цахимаар солилцох ажлын хурээнд доорх ажлуудын хөгжүүлэлт дууссан, 2024-09 сард туршилт хийсэн. <ul style="list-style-type: none"> - Импортын зөвшөөрөл олгогдсоны дараа КАИС системд сервисээр мэдээллийг авч хадгала. <ul style="list-style-type: none"> - Импортын гаалийн мэдүүлэгт химийн хорт бодисын зөвшөөрлийг татаж бичнэ. - Мэдүүлэг баталгаажсаны дараа барааны тоо хэмжээг БОЯ-руу илгээнэ. - Одоогоор Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам нь системийн хөгжүүлэлт хийгдэж байгаа бөгөөд тус систем нь дууссаны дараа 2 системийг холбож, нэвтрүүлэх ажил хүлээгдэж байна. • ГЕГ-ын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар хороодоос ирсэн мэдээллийн технологийн төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээ хийх, системүүдэд үүссэн асуудал, систем ашиглалтын талаар заавар зөвлөгөө авах, сүлжээний хэвийн ажиллагааг хангах, шалгах зэрэг тайлант хугацаанд нийт 465 дуудлага хүлээн авсан бөгөөд дуудлага хүлээн авсан төрөл, дуудлагын агуулга зэргээр дараах байдлаар төрөлжүүлсэн. <p>Хорио цээрийн програм</p> <ul style="list-style-type: none"> • БНХАУ болон Монгол улсын хамтын ажиллагааны хэлэлцээрээр “Мал эмнэлгийн гэрчилгээ”-ний шинэчлэгдсэн загвар батлагдсаны дагуу APQS системд нэмэлт хөгжүүлэлт хийлгэх хүсэлтийг Хорио цээрийн газраас ирүүлсэний дагуу хорио цээрийн APQS системд нэмэлт хөгжүүлэлт хийсэн. • Хүнс хөдөө аж ахуйн яам, Мал эмнэлгийн газар болон Хорио цээрийн албанд импортын эрсдэлийн үнэлгээ хийлгэж зөвшөөрөл авсан нийт 21 ААН-ийн мэдээллүүдийг тус програмд бүртгэсэн. • Тус програмд иргэд зөвхөн нэг байгууллага бүртгүүлэх боломжтой байсныг нэмэлт хөгжүүлэлт хийж иргэд өөрт бүртгэлтэй нэгээс олон байгууллагыг нэмэх, засах боломжтой болгосон. 		
--	--	--	--	--	--	--

				<ul style="list-style-type: none"> Төрийн үйлчилгээг сайжруулах цахимжуулах зорилтын хүрээнд гэрчилгээ мэдэгдлийг баталгаажуулсан тохиолдолд иргэд аж ахуйн нэгж өөрсдийн системээс харах болон хэвлэн авах боломжтой болгож CAPS системийн үйл ажиллагааг сайжруулав. 	01.01-11.30	100
3	Албан хаагчдын чадавхыг бэхжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>-</p> <p>1. Гаалийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн харууцсан албан хаагчдыг технологийн чиглэлээр чадавхжуулах боломжийг хангаж ажигласан байна.</p>	<p>1. Мэдээллийн технологийн асуудал харууцсан албан хаагчдыг мэдээллийн технологийн чиглэлээр чадавхжуулах боломжийг хангах ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> Монгол Улсын Ерөнхий сайдын "2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгаврын 5.5 дугаарт авлигатай тэмцэх "5Ш" ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжилт, үр дүнг олон нийтэд тогтмол мэдээллэх хуулийн дагуу SHILEN.GOV.MN системийн сургалтад сууж Гаалийн байгууллагын Шилэн системийн админаар томилогдон ажиллаж байна. 2024.08.15ны өдөр Novelsoft ХХК-иас Mulesoft програмын сургалтад хамрагдсан. ГУБ Б.Энх-Амгалан WSO хэрэгжүүлж буй Data Analytics онлайн сургалтын Intermediate түвшиний сургалтын эхний бүлгийн 7 хичээлийг үзэж 3 шалгалтыг амжилттай өгч эхний бүлэг хичээлийг үзэж дуусгасан. ГУБ Б.Энх-Амгалан Дэлхийн гаалийн байгууллагын siкс.woosoft.org платформийн хэрэгжүүлж буй machine learning хөтөлбөрт цахимаар бие даан суралцсан. Өгөгдлийг өөр хооронд нь холбох, шинжлэн нэгтгэх, интерактив дашбоард боловсруулах зэрэг өгөгдөл дүрслэлийн ур чадварыг өндөр түвшинд эзэмших Tableau Desktop 1&11 түвшин буюу анхан шатны сургалтад 2024.10.23-2024.10.24-ны хооронд хамрагдсан. 2. Зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын албан хаагчдад мэдээ, мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулах ажлын хүрээнд: 	01.01-11.30	100

				<ul style="list-style-type: none"> • Өгөгдлийг өөр хооронд нь холбох, шинжлэн нэгтгэх, интерактив дашбоард боловсруулах зэрэг өгөгдөл дүрслэлийн ур чадварыг өндөр түвшинд эзэмших Tableau Desktop 1&11 түвшин буюу анхан шатны сургалтыг Novelsoft компанитай хамтран 2024.10.23-2024.10.24-ны хооронд зохион байгуулсан. <p>3. Гаалийн байгууллага болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт:</p> <ul style="list-style-type: none"> • 2024 оны 09 сарын 25 өдрийн "Эрсдэлийн удирдлагын онол, практикийн асуудал" сургалтанд ГУБЗ.Алтанхуяг, Б.Энх-Амгалан нар хамрагдсан. • 2024.09.25-нд "Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих дашбоард хөгжүүлэх" ажлын хэсгийн уулзалтад оролцсон. 	01.01-11.30	100
4	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	- 1.Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож сан үүсгэн, түүнд дүн шинжилгээ хийж бууруулах арга хэмжээг авч ажиллана. 2.Бууруулсан эрсдэлийг санд бүртгэсэн талаар болон нэгжийн үйл ажиллагаанд учирсан ач холбогдол, үр дүнгийн талаар оновчтой тайлагнасан байна	<p>Мэдээллийн технологийн (МТ) салбарт эрсдэлийг удирдах нь байгууллагын үйл ажиллагааны найдвартай байдал, өрсөлдөх чадварыг хадгалахад чухал үүрэгтэй. Гаалийн байгууллагын Мэдээллийн технологийн газрын эрсдэлийг тодорхойлох нь байгууллагын мэдээллийн системийн найдвартай байдал, аюулгүй ажиллагаа, үр ашигтай байдлыг хангах чухал үндэс суурь юм. Мэдээллийн технологийн эрсдэлд хамаарах хүчин зүйлс нь байгууллагын мэдээллийн систем, өгөгдөл, тоног төхөөрөмж, ажилтнууд болон гадаад орчны олон талт нөлөөнөөс шалтгаалж үүсэж боломжтой.</p> <p>МТГ-с үйл ажиллагаа, чиг үүргийг нарийвчлан судалж, байгууллагын мэдээллийн технологийн чиглэлд гарч болзошгүй дараах эрсдэлийн хүчин зүйлсийг тодорхойлсон.</p> <ul style="list-style-type: none"> • Тоног төхөөрөмжийн эвдрэл • Сүлжээ, системийн тасалдал • Програм хангамжийн алд аа • Кибер халдлага • Мэдээллийн алдагдал • Мэргэшсэн ажилтны дутагдал • Сургалт, хөгжлийн дутагдал • Хүний нөөцийн тогтворгүй байдал • Байгалийн гамшиг • Төсвийн дутагдал <p>Үнэлгээний аргачлал нь эрсдэл бүрийг магадлал (тохиолдох боломж) болон нөлөөллийн (тохиолдсон тохиолдолд үзүүлэх нөлөө) түвшинг тодорхойлж, эрсдэлийн матрицад байршуулсан. Эрсдэлийн матрицад байршуулсанаас харахад өндөр, дунд, бага эрсдэлд дараах</p>		

			<p>хүчин зүйлс орсон бөгөөд эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө гаргасан.</p> <p>Тонгог төхөөрөмжийн эвдрэл, сүлжээ тасалдал, төсвийн дутагдал зэрэг эрсдэлүүд байгууллагын үйл ажиллагаанд ноцтой нөлөө үзүүлэх тул яаралтай хяналт, шийдэл шаардлагатай. Технологийн шинэчлэл, мэргэшсэн ажилтны дутагдал зэрэг асуудлууд нь үйл ажиллагаанд зарим саад учруулж болох ч урт хугацаанд илүү том асуудал болж хувирах магадлалтай. Байгалийн гамшиг нь ховор тохиолддог ч тохиолдсон үед их хэмжээний нөлөө үзүүлдэг тул нөөц төлөвлөгөө шаардлагатай.</p>		
5	<p>Үүрэг даалгаврын биелэлт</p>	<p>Хэрэгжилт, гүйцэтгэлээр</p>	<p>-</p> <p>1. Захиргааны зөвлөлийн хуралдаан Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Онлайн, Шуурхайгаас болон бусад хэлбэрээр удирдлагаас өгөгдсөн нийт үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж, тухай бүр тайлагнасан байна.</p>	<p>01.01-11.30</p>	<p>100</p>
6	<p>Ажлын цаг ашиглалт</p>	<p>Хэрэгжилт, гүйцэтгэлээр</p>	<p>-</p> <p>Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулж, цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид тогтмол бүртгүүлж, гадур ажилласан, өвчтэй, чөлөөтэй тохиолдол бүрт СЕРП программаар тухай бүр илгээж ажилласан байна.</p>	<p>01.01-11.30</p>	<p>100</p>
7	<p>Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.27 Цахим гарын үсгийг гаалийн байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх/</p>	<p>Хэрэгжилт, гүйцэтгэлээр</p>	<p>-</p> <p>1. Системийн хэмжээнд удирдлагууд, хяналт, шалгалт хийж буй гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч нарыг тоон гарын үсэгтэй болгож тоон гарын үсгийг гаалийн мэдээллийн систем рүү нэвтрэх, бичиг</p>	<p>01.01-11.30</p>	<p>100</p>

			Баримтыг үнэлэх, хяналт, шалгалт хийх, зөвшөөрөл өгөх үйлдлүүд болон гаалийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашигладаг болсон байна. 2. Төрийн болон төрийн бус байгууллагатай харилцахдаа тоон гарын үсгийг ашиглаж эхэлсэн байна	Шаралт хийж саис системтэй холбосон бөгөөд мөн ЗУГГ-ын дарга ахлах байцаагч нарын 121ш тоон гарын үсгийн 1жилийн сунгалтыг тус гаалийн газарт томилголтоор ажиллан газар дээр шарж саис системтэй холбон хүлээлгэн өгсөн байгаа. УБГГ-ын 140ш дарга ахлах байцаагч нарын тоон гарын үсгийн шарах ажил хийгдэж байна. Мөн Газар хороодын дарга нарын 14ш тоон гарын үсгийг шарж бэлэн болгосон тараах ажлыг хийж байна. • Гаалийн ерөнхий газрын дарга болон хэлтсийн дарга нарт тоон гарын үсгийн гэрчилгээ суулгаж авсан бөгөөд гаалийн үндсэн систем болох SAIS системтэй холбож, хэрэглээнд нэвтрүүлсэн. 2. Төрийн болон төрийн бус хувийн хэвшил ХХК байгууллагатай албан бичиг цахимаар солилцох ажлын хүрээнд ДОСХ дундын системтэй архив бичиг хэргийн систем болох ИДок систем гаалийн ерөнхий газар болох харьяа гаалийн 19 газар хороод бүрэн холбогдсон ба тус дундын системээр дамжуулан төрийн болон төрийн бус хувийн 4000 гаруй байгууллагуудтай тоон гарын үсэг ашиглан тоон гарын үсгээрээ баталгаажуулалт хийж цахимаар албан бичиг солилцохыг бүрэн нэвтрүүлсэн.		
--	--	--	---	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
1	Дэлхийн гаалийн байгууллагын Data Analytics Advanced (HS Recommendation) чиглэлээр бие даан сурах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор	-	HS codes using Doc2Vec algorithm хэрхэн ашиглах талаар суралцах	Дэлхийн гаалийн байгууллагын Data Analytics Advanced (HS Recommendation) чиглэлээр бие даан суралцаж эхний шатны шалгалт өгч, 2 хэсгийн сургалтанд амжилттай хамрагдаж, сертификат авсан.	01.01-11.30	100
2	Англи хэлний мэдлэгээ сайжруулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Англи хэлний мэдлэгээ	Англи хэлний мэдлэгээ сайжруулах зорилгоор бие даан онлайнгаар сурч мэдлэгээ дээшлүүлсэн.	01.01-11.30	100

зорилгоор даан онлайнаар сурах	Бие			Дээшлүүлсэн байна.			
--------------------------------	-----	--	--	--------------------	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

МЭДЭЭЛГИЙН ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ГАЛГИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

/Б.ЭНХ-АМГАЛАН/

2024 ОНЫ 12 ДУГААР 10-НЫ ӨДӨР

1188
 ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.ЭНХ-АМГАЛАНГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,
 ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
 Нэгжийн нэр: Мэдээллийн технологийн газар

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Мэдээллийн нэгдсэн санд дүн шинжилгээ хийж, өгөгдлийг боловсруулсан байдал	58	7	65	
2.	Программ хангамжуудыг шинээр боловсруулах, хөгжүүлсэн байдал	60	10	70	
3.	Албан хаагчдын чадавхыг бэхжүүлсэн байдал	52	10	62	
4.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	56	8	64	
5.	Үүрэг даалгаврын биелэлт	60	9	69	
6.	Ажлын цаг ашиглалт	58	7	65	
7.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.27 Цахим гарын үсгийг гаалийн байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх/	58	8	66	

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Дэлхийн гаалийн байгууллагын Data Analytics Advanced (HS Recommendation) чиглэлээр бие даан сурах	80	12	

2.	Англи хэлний мэдлэгээ сайжруулах зорилгоор бие даан онлайнаар сурах	100	15
Дундаж оноо:			13.5

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	6	
2.	Асуудал шийдвэрлэх	6	
3.	Хариуцлагатай байдал	6	
4.	Дүн шинжилгээ хийх	6	
5.	Ажлын цаг ашиглалт	6	
Дундаж оноо:			6

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	6
2.	Багаар ажиллах	7
3.	Харилцаа	8
Дундаж оноо:		7

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	65.8
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13.5
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	

Нийт оноо =	92.3
(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ))- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо	

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Мэдээллийн технологийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



(Б.Ганзориг)

2024.12.10 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч: зөвшөөрсөн:

Гаалийн улсын байцаагч




(Б.Энх-Амгалан)

2024.12.10 (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч




(Г.Энхтайван)

2024.12.10 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн Гаалийн улсын ахлах байцаагч



(Ө.Тэгшээ)

2024.12.10 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

Гаалийн ерөнхий газрын дарга



(Р.Отгонжаргал)

.....(огноо)